



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/052/НА-СТА-ТШЗ

| | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор Д.Эрдэнэбулган Утас: 89818085 Цахим хаяг: Erdenebulgandab@audit.gov.mn |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---------------------------------------------------------------------------|----|
| 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| Асуудлыг онцолсон хэсэг..... | 3 |
| Аудитын гол асуудал | 3 |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 7 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 14 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 17 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 17 |
| 4.2 Материаллаг байдал..... | 17 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 17 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 17 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 17 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 18 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 18 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 18 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 18 |
| 5.1 Төлбөрийн акт | |
| 5.2 Албан шаардлага | |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖИМТ
ДРАМЫН ТЕАТРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ТАЙВАНБОЛД ТАНАА

2025.02.20 № 2/19
танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн хөгжимт драмын театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн хөгжимт драмын театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

5020182

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 16 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>416,331,317.54</u> | <u>459,623,667.00</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 4,851,700.54 | 00.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 4,851,700.54 | 00.00 |
| 3121 | Төгрөг | 4,851,700.54 | 00.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,851,700.54 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 411,479,617.00 | 459,623,667.00 |
| 351 | Түүхий эд материал | 99,000.00 | 66,750.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 99,000.00 | 66,750.00 |
| 354 | Хангамжийн материал | 408,830,617.00 | 457,006,917.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,953,992.00 | 6,832,092.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 27,295,300.00 | 43,698,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 80,000.00 | 80,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 375,501,325.00 | 406,396,825.00 |
| 35600 | Мал амьтад | 2,550,000.00 | 2,550,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,028,636,705.47</u> | <u>1,019,893,427.93</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,028,636,705.47 | 1,019,893,427.93 |
| 392 | Биет хөрөнгө | 814,031,705.66 | 797,488,427.99 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,635,330,707.66 | 1,635,330,707.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -972,563,901.96 | -1,002,032,995.68 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 65,500,000.00 | 65,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -54,541,666.56 | -62,083,333.20 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 427,666,182.60 | 438,725,899.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -332,745,507.76 | -326,904,553.35 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 169,331,503.00 | 172,300,044.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -163,481,211.32 | -162,470,441.04 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 37,000,000.00 | 37,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,900,000.00 | 7,900,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,250,000.00 | -6,662,500.00 |
| 39217 | Ном | 885,600.00 | 885,600.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 214,604,999.81 | 222,404,999.94 |
| 39301 | Програм хангамж | 2,130,000.00 | 2,130,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 249,887,355.00 | 258,187,355.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -36,962,355.19 | -37,462,355.06 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,444,968,023.01</u> | <u>1,479,517,094.93</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>67,681.00</u> | <u>67,681.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 67,681.00 | 67,681.00 |
| 413 | Өглөг | 67,681.00 | 67,681.00 |
| 4136 | Бусад өглөг | 67,681.00 | 67,681.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 67,681.00 | 67,681.00 |

| | | | |
|-------|-----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,444,900,342.01 | 1,479,449,413.93 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,444,900,342.01 | 1,479,449,413.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 945,688,163.91 | 945,688,163.91 |
| 51101 | Өмч: - төрийн | 945,688,163.91 | 945,688,163.91 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -863,292.59 | 34,205,779.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -863,292.59 | -343,292.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 34,549,071.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 500,075,470.69 | 499,555,470.69 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,444,968,023.01 | 1,479,517,094.93 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,827,694,629.66 | 2,190,204,492.77 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 73,029,950.00 | 45,698,335.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 73,029,950.00 | 44,650,160.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,029,950.00 | 44,613,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 24,029,950.00 | 42,713,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 1,900,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 36,660.00 |
| 122 | Тусламжийн орлого | 00.00 | 1,048,175.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 1,048,175.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,754,664,679.66 | 2,144,506,157.77 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,484,516,479.66 | 1,827,858,157.77 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,484,516,479.66 | 1,827,858,157.77 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 270,148,200.00 | 316,648,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 270,148,200.00 | 316,648,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,761,864,476.48 | 2,155,655,420.85 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,761,864,476.48 | 2,155,655,420.85 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,544,023,819.29 | 2,079,644,754.14 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,033,155,336.44 | 1,496,243,244.28 |
| 210101 | Үндсэн цалин | 709,600,837.61 | 1,043,387,307.63 |
| 210102 | Нэмэгдэл | 180,290,439.49 | 286,385,172.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,089,128.89 | 55,463,000.00 |
| 210104 | Урамшуулал | 92,174,930.45 | 111,007,763.73 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 128,940,792.71 | 169,287,358.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,700,049.73 | 110,161,501.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,317,652.83 | 14,946,627.13 |
| 210203 | ҮОМШО-ний даатгал | 8,254,122.13 | 8,351,452.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,053,913.08 | 6,421,973.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,615,054.94 | 29,405,804.18 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 258,471,986.81 | 292,819,774.87 |

| | | | |
|-------------|---------------------------------------------------------------------------------------|-----------------------|----------------------|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,410,614.81 | 7,741,134.87 |
| 210302 | Түлш, халаалт | 246,301,440.00 | 279,510,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,759,932.00 | 5,568,640.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 32,919,850.62 | 24,007,924.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,106,000.00 | 5,555,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,617,065.00 | 8,172,926.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,421,135.62 | 2,515,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,125,600.00 | 1,336,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,650,050.00 | 6,427,848.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,782,000.00 | 12,156,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,782,000.00 | 12,156,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 00.00 | 2,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 2,500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,440,792.00 | 7,434,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,264,408.00 | 7,434,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 435,184.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 806,200.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,313,060.71 | 75,195,252.54 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,429,896.00 | 230,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрөнгө | 66,883,164.71 | 74,965,252.54 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 217,840,657.19 | 76,010,666.71 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 214,164,444.00 | 30,097,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,939,500.00 | 5,973,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 48,547,800.00 | 22,123,400.00 |
| 213208 | Ходоо орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад тороос үзүүлэх дэмжлэг | 159,909,144.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 768,000.00 | 2,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 27,085,441.58 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 27,085,441.58 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,676,213.19 | 18,828,225.13 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,676,213.19 | 18,828,225.13 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 65,830,153.18 | 34,549,071.92 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 3,562,500.20 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 3,562,500.20 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -3,562,500.20 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 62,267,652.98 | 34,549,071.92 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,778,694,629.66 | 2,187,256,317.77 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 24,029,950.00 | 42,750,160.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 24,029,950.00 | 42,750,160.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,029,950.00 | 42,713,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 24,029,950.00 | 42,713,500.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 36,660.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,754,664,679.66 | 2,144,506,157.77 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,484,516,479.66 | 1,827,858,157.77 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,484,516,479.66 | 1,827,858,157.77 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 270,148,200.00 | 316,648,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 270,148,200.00 | 316,648,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,739,792,101.44 | 2,192,108,018.31 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,739,792,101.44 | 2,192,108,018.31 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,521,951,444.25 | 2,116,097,351.60 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,033,383,826.11 | 1,483,187,333.68 |
| 210101 | Үндсэн цалин | 709,600,837.61 | 967,131,674.65 |
| 210102 | Нэмэгдэл | 180,518,929.16 | 327,591,961.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,089,128.89 | 55,463,000.00 |
| 210104 | Урамшуулал | 92,174,930.45 | 133,000,697.34 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 128,940,792.71 | 182,343,269.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,700,049.73 | 124,044,325.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,317,652.83 | 14,703,817.62 |
| 210203 | ҮОМШО-ний даатгал | 8,254,122.13 | 8,112,178.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,053,913.08 | 6,441,509.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,615,054.94 | 29,041,438.33 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 258,471,986.81 | 292,819,774.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,410,614.81 | 7,941,884.87 |
| 210302 | Түлш, халаалт | 246,301,440.00 | 279,510,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,759,932.00 | 5,367,890.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,487,450.62 | 28,759,574.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,696,800.00 | 6,206,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,617,965.00 | 8,172,926.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,421,135.62 | 2,455,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,125,600.00 | 1,336,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,626,850.00 | 10,589,398.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,000,000.00 | 63,373,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 39,991,800.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 7,636,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 15,744,500.00 |

| | | | |
|--------|---------------------------------------------------------------------------------------|-----------------------|----------------------|
| 2107 | Томилолт, зочны зардал | 00.00 | 2,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 2,500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 49,050,092.00 | 58,324,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 48,870,092.00 | 55,924,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,000,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.00 | 1,400,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,617,296.00 | 4,790,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,617,296.00 | 4,790,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 217,840,657.19 | 76,010,666.71 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 214,164,444.00 | 30,097,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,939,500.00 | 7,973,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 48,547,800.00 | 22,123,400.00 |
| 213208 | Ходоо орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 159,900,144.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 768,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 27,085,441.58 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 27,085,441.58 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,676,213.19 | 18,828,225.13 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,676,213.19 | 18,828,225.13 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 38,902,528.22 | -4,851,700.54 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 35,862,000.00 | 00.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 35,862,000.00 | 00.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 35,862,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 35,862,000.00 | 00.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -35,862,000.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 3,040,528.22 | -4,851,700.54 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,811,172.32 | 4,851,700.54 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,851,700.54 | 00.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-------|----------------------------------------|
| C01 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 945,688,163.91 | 492,075,470.69 | -41,232,675.39 | 00.00 | 1,396,530,959.21 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 945,688,163.91 | 492,075,470.69 | -41,232,675.39 | 00.00 | 1,396,530,959.21 |

| | | | | | | |
|-----|--------------------------------------------------|-----------------------|-----------------------|----------------------|--------------|-------------------------|
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -13,857,655.52 | 00.00 | -13,857,655.52 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 945,688,163.91 | 500,075,470.69 | -863,292.59 | 00.00 | 1,444,900,342.01 |
| D01 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 945,688,163.91 | 500,075,470.69 | -863,292.59 | 00.00 | 1,444,900,342.01 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 520,000.00 | 00.00 | 520,000.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 945,688,163.91 | 500,075,470.69 | -343,292.59 | 00.00 | 1,445,420,342.01 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -520,000.00 | 00.00 | 00.00 | -520,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 34,549,071.92 | 00.00 | 34,549,071.92 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 945,688,163.91 | 499,555,470.69 | 34,205,779.33 | 00.00 | 1,479,449,413.93 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|-----------------------|-------------------------------------------------------|-----------------------|------------------|-----------------|------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт хэмнэлт | Хувь |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 4851700.54 | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,185,029,200.00 | 2,146,194,351.60 | 38,834,848.40 | 98.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,185,029,200.00 | 2,146,194,351.60 | 38,834,848.40 | 98.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,185,029,000.00 | 2,116,097,351.60 | 68,931,648.40 | 96.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,498,034,600.00 | 1,483,187,333.68 | 14,847,266.32 | 99.0 |
| 210101 | Үндсэн цалин | 947,058,000.00 | 966,321,416.65 | 19,263,416.65 | |
| 210102 | Нэмэгдэл | 366,174,000.00 | 327,591,961.69 | 38,582,038.31 | 89.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 61,728,000.00 | 55,463,000.00 | 6,265,000.00 | 89.8 |
| 210104 | Урамшуулал | 123,074,600.00 | 133,810,955.34 | 10,736,355.34 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 186,844,200.00 | 182,343,269.05 | 4,500,930.95 | 97.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 127,054,100.00 | 124,044,325.72 | 3,009,774.28 | 97.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,947,600.00 | 14,703,817.62 | 243,782.38 | 98.3 |
| 210203 | ҮОМШО-ний даатгал | 7,473,700.00 | 8,112,178.17 | -638,478.17 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,473,700.00 | 6,441,509.21 | 1,032,190.79 | 86.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,895,100.00 | 29,041,438.33 | 853,661.67 | 97.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 316,648,000.00 | 297,819,774.87 | 18,828,225.13 | 94.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,500,000.00 | 7,741,134.87 | 758,865.13 | 91.2 |

| | | | | | |
|---------------|----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|----------------------|-------------|
| 210302 | Түлш, халаалт | 298,148,000.00 | 279,510,000.00 | 18,638,000.00 | 93.7 |
| 210303 | Цэвэр, бөхир ус | 5,000,000.00 | 5,568,640.00 | -568,640.00 | |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 | 0.00 | 100 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,275,600.00 | 27,870,174.00 | 405,426.00 | 98.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,200,000.00 | 6,206,050.00 | 993,950.00 | 86.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,200,000.00 | 8,172,926.00 | -972,926.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,975,600.00 | 2,455,200.00 | 520,400.00 | 82.5 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал | 1,200,000.00 | 1,336,000.00 | -136,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,700,000.00 | 9,699,998.00 | 2.00 | 100 |
| 2105 | Нормативт зардал | 00.00 | 00.00 | 0.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 00.00 | 0.00 | 0.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 59,262,600.00 | 59,262,600.00 | 0.00 | 100 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 39,991,800.00 | 39,991,800.00 | 0.00 | 100 |
| 210602 | Тавилга | 5,600,000.00 | 5,600,000.00 | 0.00 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 13,670,800.00 | 13,670,800.00 | 0.00 | 100 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,700,000.00 | 2,500,000.00 | 200,000.00 | 92.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,700,000.00 | 2,500,000.00 | 200,000.00 | 92.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 58,367,200.00 | 58,324,000.00 | 43,200.00 | 100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 55,947,200.00 | 55,924,000.00 | 23,200.00 | 100 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,420,000.00 | 1,400,000.00 | 20,000.00 | 98.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4800000.00 | 4790200.00 | 9,800.00 | 100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,800,000.00 | 4,790,200.00 | 9,800.00 | 100 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 30097000.00 | 30097000.00 | 0.00 | 100 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 30,097,000.00 | 30,097,000.00 | 0.00 | 100 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,973,600.00 | 7,973,600.00 | 0.00 | 100 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22,123,400.00 | 22,123,400.00 | 0.00 | 100 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,185,029,200.00 | 2,146,194,351.60 | 38,834,848.40 | 98.2 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,185,029,200.00 | 2,146,194,351.60 | 38,834,848.40 | 98.2 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,185,029,200.00 | 2,146,194,351.60 | 38,834,848.40 | 98.2 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | 42,713,500.00 | 42,713,500.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 42,713,500.00 | 42,713,500.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 4,851,700.51 | -4,851,700.51 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 00.00 | 0.00 | |

| | | | | | |
|--------|-------------------------|-------|-------|------|--|
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 60.00 | 60.00 | 0.00 | |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 49.00 | 49.00 | 0.00 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 | 0.00 | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нь “Хүн амд хүргэх соёлын үйлчилгээг өргөтгөх, урлагийн бүх төрлийг хөгжүүлэх, түүнийг нийгэм эдийн засгийн бүх салбартай холбох, үндэсний уламжлалт болон сонгодог урлагийг хөхүүлэн дэмжих, соёлын урлагийн үнэт өвийг түгээн дэлгэрүүлж, сурталчлах, орчин үеийн уран бүтээлийн чанар, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрөөс баримтлах Соёлын бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлэх” эрхэм зорилготой тус байгууллага нь удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 49, гэрээт ажилтан 10 нийт 60 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Б.Пүрэвлагаа 2024 оны 05 дугаар сарын 30 өдөр хүртэл, Н.Тайванболд 2024 оны 6 дүгээр 26-ны өдрөөс, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Энхжаргал нар зурж, 2024 оны 10 дугаар сарын 23 хүртэл эд хариуцагчын нярав, кассын нярав С.Долгормаа, 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс Б.Халиун эд аж ахуйн нярваар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийгмийн даатгалын тухай, Соёлын тухай хууль, Соёлын өвийн тухай хууль, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй. Дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аймгор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх үнэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв тодилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн БОХ-ээс баримт гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж,



нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-ийн стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт өрөөгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,549.1 мянган төгрөгөөр буюу 2,3% хувиар өсч 1,479,517.1 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------------------------------------|--------------------|--------------------|-----------------|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 4,851.7 | 0,0 | |
| Авлага | 0,0 | 0,0 | |
| Бараа материал | 411,479.6 | 459,623.6 | 48,144.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,028,636.7 | 1,019,893.1 | -8,743.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | 66,883.2 | 74,965.2 | 8,082.0 |
| Нийт хөрөнгө | 1,444,968.0 | 1,479,517.1 | 34,549.1 |
| Өр төлбөр | 67,6 | 67,6 | 0,0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,444,900.3 | 1,479,449.4 | 34,549.1 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,444,968.0 | 1,479,517.1 | 34,549.1 |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансад нь үндсэн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хөгжимт драмын театр нь 2024 он санхүүгийн тайлангийн жилд авлагагүй, 67,6 мянган төгрөгний өглөгтэй байна. Өмнөх оны өглөгийг барагдуулах арга хэмжээ ажилгүй байна.

Бараа материал өмнөх оноос 48,144.0 мянга төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант жилийн зардлаас 36,111.9 мянган төгрөгийн аж ахуйн материал (бүжгийн анги, хөгжимчдийн дууны анги, студийн өрөөг тохижуулсан), 31,362.0 мянган төгрөгийн бусад хандлагийн материал (хөгжмийн зэмсэг, хөгжмийн зэмсгийн туслах материал, уран бүтээлчдийн хувцас хэрэгсэл), 6,434.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 8,172.9 мянган төгрөгийн шатахуун, худалдан авсанаар тус данс өсөхөд нөлөө үзүүлжээ. Бараа материалын үлдэгдэл 459,623.6 мянган төгрөг байна.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын үндсэн хөрөнгө өмнөх оноос 8,743.2 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 1 дугаар сарын 12-ны өдрийн 2/13 дугаар тогтоолоор 41,262.2 мянган төгрөгний тоног хөрөнгө өмж, 2,519.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил акталснаар үндсэн хөрөнгө буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвөөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагчид тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 220,950.0 мянга, улсын төсвийн санхүүжилтээр 1,693,577.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 90,698.0 мянган төгрөг нэмж 311,648.0 мянган төгрөгөөр, улсын төсвийн санхүүжилтээс 335,083.8 мянган төгрөг хасч 1,548,493.3 мянган төгрөгөөр баталсан нь цалингийн зардал, хангамжийн материалын зардлыг хасч баталснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 319,887.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 2,185,029.2 мянган төгрөгөөр баталсан нь Засгийн газрын туслоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн зөв, үндсэн үйл ажиллагааны орлого 42,713.5 мянган төгрөг төвлөрүүлснээс хангамжийн материалд 4,043.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 33,190.3 мянган төгрөг зарцуулж, 3,280.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсвийн гүйцэтгэл 2,146,194.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 297,819.7 мянган төгрөг байна. Оны эцэст орон нутгийн зардлын хэмнэлтийн 18,828.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, улсын төсвийн хэмнэлтээс 27,085.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянга, төгрөгөөр)

| № | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хөрөнө | Үнэмлэж |
|---|-----------------------------------------------------------------------------|-------------|-------------|----------|---------|
| 1 | 80101 үндсэн үйл ажиллагааны зардал Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 1,712,577.5 | 1,696,083.5 | 16,494.0 | 100.0 |
| 2 | 80214 Уран бүтээл хийлгэх | 40,000.0 | 40,000.0 | 0.0 | 100.0 |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 22,023.4 | 22,123.4 | 0.0 | 100.0 |
| 4 | 83603 Дээд шатны төсвөөс хуваарьласан. (Өөрийн орлого) | 40,523.1 | 37,198.5 | 3,324.6 | 91.7 |
| 5 | 81855 Гүйцэтгэлд сууртлсан санхүүжилт | 53,157.2 | 53,009.2 | 148.0 | 99.7 |
| 6 | 80111 тогтмол зардал | 316,648.0 | 297,819.7 | 18,828.3 | 93.8 |
| | дүн | 2,185,029.2 | 2,146,194.3 | 38,871.9 | 98.2 |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардалын зүйлсээр бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, тусгай холбогдох үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлд тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн зардал гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2024 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дагалдсан аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэл, хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тайлагналтаа үргэлжлэн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэбулган гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, танилцуулах аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ний өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүдэлтээр "Хяналт журмын батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Зөв" гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 2,185,000.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 21,850.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 14,202.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагаг үгүйсгэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын үр дүн

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээр үндэд нь оруулах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийцлийн стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.mindans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянхонгор Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн барим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансанд тухай хэмжээ тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг “Номгон аудит” ХХК-ийн аудитор О.Мандах гүйцэтгэж, “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч, аудитын тайлангаар 1,116,0 мянган төгрөгөөр 1 шийдвэрийг өгсөн, хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн FAS системд оруулж, албан ёсоор хэрэгжүүлж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биедэл | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хуви |
| Акт | 1 | 1,116.0 | 1 | 1,116.0 | 100% |
| Нийт дүн | 1 | 1,116.0 | 1 | 1,116.0 | 100% |

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн FAS систем, ирүүлсэн холбогдох баримт материал

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---

